



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 11 дүгээр сарын 29
№44 (1292)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

554.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 96	3355
555.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 97	3357
556.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай	Дугаар 98	3359

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

557.	Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 88	3360
558.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 102	3361

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

559.	Журам батлах тухай	Дугаар 185	3362
------	--------------------	------------	------

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

560.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 03	3366
561.	Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай	Дугаар 04	3375

390.	Հայաստանի մեծ հայրենի և հայրենասիրական զորքերի հերոսների և հայրենասիրական զորքերի մարտիկների համառոտագրությունը . Երևան, 1993 թ. 92 էջ . Գրքեր 5-9 . Վրդ. Մանուկյան / Իր արվեստի և ստեղծագործության մասին . Երևան, 1993 թ. 44 էջ .	Գրքեր	03	ՀՀԳԳ
390.	Մեծըք Փոլո_ զա Փոլտոսոզ Հոլլի Ազ Շոզ Ազ Ծոսեղեղեղե	Գրքեր	04	ՀՀԳԳ
390.	Սարգիս Մանուկյանի մասին . Երևան, 1993 թ. 3 էջ . Գրքեր 5-9 .	Գրքեր	04	ՀՀԳԳ
391.	Մեծըք Փոլո_ զա Լեզ զա Գլե՞ զա Ծոսեղեղե	Գրքեր	04	ՀՀԳԳ
392.	Հայաստանի զորքերի և հայրենասիրական զորքերի հերոսների և հայրենասիրական զորքերի մարտիկների համառոտագրությունը . Երևան, 1993 թ. 92 էջ . Գրքեր 5-9 .	Գրքեր	04	ՀՀԳԳ
392.	Մեծըք Փոլո_ զա Կրօսիկի Մարլի իւա Լըրի(Գրքեր	04	ՀՀԳԳ
393.	Հայաստանի զորքերի և հայրենասիրական զորքերի հերոսների և հայրենասիրական զորքերի մարտիկների համառոտագրությունը . Երևան, 1993 թ. 92 էջ . Գրքեր 5-9 .	Գրքեր	04	ՀՀԳԳ
393.	Մեծըք Փոլո_ զա Կեղի Հորեղ զա Ծոսեղեղե	Գրքեր	04	ՀՀԳԳ
394.	Մեծըք Փոլո_ զա Կեղի Հորեղ զա Ծոսեղեղե	Գրքեր	05	ՀՀԳԳ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Лувсандоржийн Өлзийсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Доржийн Одбаярыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын дээд шүүхийн санал болгосноор Одонхүүгийн Мөнхсайханыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тул Намжилын Чинбатыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

3. Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Мэдэгдэл, цагдаагийн алба хаагчид зориулсан

Мэдэгдэл, цагдаагийн алба хаагчид зориулсан / 2023 оны 44 дугаар тогтоол /

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА

МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА
МОНГОЛ УЛСЫН ЦАГДААГИЙН АЛБА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 98

Улаанбаатар
хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

- 1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал болгосноор Эрдэнээгийн Энхтуяаг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.
- 2.Энэ тогтоолыг 2023 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Mongolia Folio_02 Yuki Norge 02 Docx168x

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠤᠯᠤᠰ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 88

Улаанбаатар
хот

Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Баттулгын Номинг Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Энхбатын Хосбаярыг Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Баатарнямын Одбаярыг Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Ядамжавын Урнааг Увс аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Ганболдын Түвшинтөгсийг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Алтансүхийн Батмандахыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Мөнхтөмөрийн Солонгоог Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Гончигийн Энхцэцэгийг Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Чимэдрэгзэнгийн Алдарыг Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Эрдэнэбаатарын Чанцалнямыг Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Отгоны Аззаяаг Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд, Ганзоригийн Төрболдыг Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2023 оны 07 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ядмаагийн Ариунболдыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Эрдэнэцогтын Сарантогосыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Соёлын тухай хуулийн 20.1.1, 33.9 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд тэтгэмж олгоход шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийж санхүүжүүлэх, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан нарт үүрэг болгосугай.

3.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

СОЁЛЫН САЙД

Ч.НОМИН

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД**

Х.БУЛГАНТУЯА



Засгийн газрын 2023 оны 05 дугаар
сарын 17-ны өдрийн 185 дугаар
тогтоолын хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫН АЖИЛТАНД МӨНГӨН ТЭТГЭМЖ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Соёлын тухай хуулийн 33.9 дэх хэсэгт заасан орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд 5 жил тутамд нэг удаа зургаан сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг (цаашид “тэтгэмж” гэх) улсын төсвөөс олгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Тэтгэмжийг Нийслэлийн Багануур, Багахангай дүүрэг болон аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд олгоно.

1.3.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд энэ журамд заасан мөнгөн тэтгэмж авах эрх нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн үүснэ.

1.4.Энэ журмын 1.1-д заасан тэтгэмжийг орон нутгийн өмчийн соёлын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаал, зэрэглэл (ТҮСҮ)-ийн албан тушаалд ажиллаж буй соёлын ажилтанд олгоно.

1.5.Соёлын ажилтан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө чөлөөлөгдсөн, халагдсан, эсхүл тэтгэврийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаа бол энэ журмын үйлчлэлд хамаарахгүй.

Хоёр.Тэтгэмж олгоход тавигдах нөхцөл

2.1.Соёлын ажилтан орон нутгийн өмчийн соёлын байгууллагад томилогдсон өдрөөс хойш тасралтгүй 5 жил (60 сар) ажилласан байна.

2.2.Дараах хугацааг энэ журмын 2.1-д заасан тасралтгүй ажилласан жилд хамааруулж тооцно:

2.2.1.жирэмсний болон амаржсаны амралттай, хууль тогтоомжийн дагуу хүүхдээ асрах чөлөөтэй байсан 36 сар хүртэлх хугацаа;

2.2.2.хугацаат цэргийн алба хаасан хугацаа;

2.2.3.ажлаас үндэслэлгүйгээр халагдсаныг шүүхээр эгүүлэн тогтоосон бол уг шалтгаанаар ажилгүй байсан хугацаа;

2.2.4.баривчлагдсан, цагдан хоригдсон этгээд, гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс суллагдсан, шүүхээс цагаатгах тогтоол гаргасан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг хүчингүй болгосон бол соёлын ажилтныг ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэсэн хугацаа;

2.2.5.байгууллагын захиалгаар 6 хүртэлх сарын хугацаагаар мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх, дахин мэргэших, шинээр мэргэжил эзэмшихээр суралцсан хугацаа;

2.2.6.зайлшгүй дэргэд нь байж асрах шаардлагатай гэр бүлийн гишүүнийг 3 хүртэл сараар сахиж, асарсан хугацаа;

2.2.7.эрүүл мэндийн шалтгааны улмаас 3 хүртэл сараар эмчлүүлсэн хугацаа;

2.2.8.гамшиг, аюул, аюулт үзэгдэл, ослын голомтын бүсэд дайчлагдан ажилласан хугацаа;

2.2.9.гурав хүртэлх насны хүүхдээ асрах хүсэлтийг нь үндэслэн соёлын ажилтанд олгосон чөлөөний 12 сар хүртэлх хугацаа.

2.3.Соёлын ажилтан орон нутгийн өмчийн соёлын байгууллага дотроо, эсхүл орон нутгийн өмчийн соёлын байгууллага хооронд шилжин болон сэлгэн ажилласан бол уг хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаанд үндэслэн тасралтгүй ажилласан гэж тооцно.

2.4.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагад дагалдан болон туршилтаар ажилласан хугацааг тасралтгүй ажилласан гэж тооцно.

Гурав.Тэтгэмж олгох

3.1.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан жил бүрийн 6 болон 12 дугаар сард багтаан тэтгэмж авах нөхцөл хангасан соёлын ажилтны тасралтгүй ажилласан хугацааг тооцож, байгууллагын удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.2.Соёлын ажилтны тэтгэмж авах эрх үүсэх хугацааг нийгмийн даатгалын лавлагаа, ажилд томилсон тушаал болон холбогдох бусад баримт бичигт үндэслэн тогтооно.

3.3.Тэтгэмжийн хэмжээ соёлын ажилтны сүүлийн 6 сарын үндсэн цалинтай тэнцүү байна.



3.4.Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын удирдлага дараагийн жилд тэтгэмж авах эрх үүсэх соёлын ажилтанд тэтгэмж олгоход шаардагдах зардлыг тооцож, 07 дугаар сарын 25-ны дотор дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газарт хүргүүлнэ:

3.4.1.соёлын ажилтанд тэтгэмж олгох нөхцөл бүрдсэнийг тодорхойлсон албан бичиг;

3.4.2.соёлын ажилтны бичгээр гаргасан хүсэлт;

3.4.3.нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаа;

3.4.4.энэ журмын 2.1-д заасан нөхцөлийг гэрчлэх баримт бичиг;

3.4.5.шаардлагатай бусад баримт бичиг.

3.5.Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газар энэ журмын 3.3-т заасан баримт бичгийн бүрдлийг нягтлан, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж, 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.6.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тэтгэмж олгоход шаардагдах хөрөнгийг улсын хэмжээнд нэгтгэн төсвийн ерөнхийлөн захирагчийн дараагийн жилийн төсвийн төсөлд тусган 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, батлуулах арга хэмжээ авна.

3.7.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хуваарилсан тэтгэмжийн зориулалттай зардлыг орон нутгийн өмчийн соёлын байгууллагаар дамжуулан соёлын ажилтанд олгох ажлыг зохион байгуулна.

3.8.Хуульд зааснаас бусад тохиолдолд мөнгөн тэтгэмжээс татвар, шимтгэл, суутгал, хураамжавах, тэтгэмжийг аливаа биет (бараа, материал г.м) болон биет бус (аяллын эрх, үзвэрийн билет г.м) хэлбэрээр орлуулж олгохгүй.

3.9.Тэтгэмжийн зориулалтаар батлагдсан хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3.10.Соёлын ажилтанд дараагийн тэтгэмж олгох хугацааг энэ журмын 2.1-д заасан эрх үүссэн өдрөөс эхлэн тооцно.

Дөрөв.Бусад

4.1.Энэ журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

----oOo----

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 08-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар
хот

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр, Ш.Солонго, Б.Буяндэлгэр /илтгэгч/, Г.Туулхүү, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн О.Баясгалан, Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн нар оролцов.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;”, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Улсын Их Хурлын 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай” 42 дугаар тогтоолыг хянан хэлэлцэв.

***Нэг. Монгол Улсын иргэн Г.Нацагдорж, О.Баясгалан нар
Үндсэн хуулийн цэцэд хандаж:***

“Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлд хэргийг түдгэлзүүлэх зохицуулалтыг тусгасан байх бөгөөд 1.3 дахь

заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол,” шүүгч хэргийг түдгэлзүүлэхээр, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг тус тус зөрчиж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааны бэлтгэл хангах ажиллагаа” гэсэн Гучин гуравдугаар бүлгийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол,” гэсэн нь Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гараагүй байхад хуулийн хэрэгжилтийг зогсоож, улмаар адил эрх хэмжээтэй шүүгдэж байгаа иргэдийн тэгш байдлыг алдагдуулах үр дагаврыг бий болгосон байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэцээс маргаан үүсгэн хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаагаас биш Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гараагүй байхад хуулийн хэрэгжилтийг зогсоож, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуулийн дагуу явагдах нөхцөлийг алдагдуулж байна. Нөгөөтэйгүүр, энэ заалт цааш үйлчилсээр байвал хэрэгт холбогдсон аливаа этгээд нь өөрт хамааралтай, эсхүл хамаарч болох заалтад холбогдуулан Цэцэд бусдаар дамжуулан мэдээлэл гаргах замаар ял зэмээс зайлсхийх боломж гарч ирнэ.

Үндсэн хуулийн цэцийн талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид “Цэц” гэнэ/ бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасан бөгөөд Цэцэд иргэдийн өргөдөл, мэдээлэл, байгууллага, албан тушаалтны хүсэлтээр маргаан үүсгэдэг. Тэгэхээр Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гараагүй байхад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлснээр төрийн үйл ажиллагаа хууль дээдлэх зарчмаас ухарч, хуулийг сахин биелүүлэх үүргээс чөлөөлөгдөх, хуулийн хэрэгжилтийг зогсоох үр дагавар бий болж байна. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу ... хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.” хэмээн заасан байхад Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд "... гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;" хэмээн утга агуулгын илэрхий алдаатай байдлаар хуульчилсан байна.

Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", харин Жаран зургадугаар зүйлд зааснаар хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт хийх эрх нь зөвхөн Цэцэд байгаа юм. Өөрөөр хэлбэл, хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлэх эрхийг Цэц эдлэх бөгөөд бусад этгээд ийм эрхийг эдлэх боломжгүй юм. Гагцхүү хуульд захирагдах ёстой, хуулийг чандлан сахих ёстой шүүгч хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлэх ёсгүй болно. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт болон 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн болохыг тогтоож өгнө үү." гэсэн агуулга бүхий мэдээлэл, гомдол гаргажээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

"... 1.Монгол Улсын иргэн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхтэй. Иргэн Үндсэн хуулиар хамгаалагдсан энэхүү эрхээ хэрэгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулиудад хэрэг түдгэлзүүлэх нөхцөлүүдийг хуульчлан заасан байдаг. Өөрөөр хэлбэл, хэргийг бүрэн шалгаж, бодит байдлыг тогтооход саад болохуйц тодорхой нөхцөлүүдийг хуульчлан тогтоосон бөгөөд энэ тохиолдолд шүүгч тодорхой нөхцөлийг арилтал хэргийг түдгэлзүүлж, уг нөхцөл арилмагц захирамж гарган хэргийг сэргээж, ажиллагааг үргэлжлүүлдэг.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт нь иргэн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар Үндсэн хуульд заасан шүүхэд гомдол гаргах эрхийг баталгаажуулсан зохицуулалтуудын нэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үр дагавартай онцлог харилцаа болохын хувьд зөвхөн уг ажиллагааны явцад буюу яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдаанд бэлтгэх шатанд онцгойлон яллагдагчид олгож байгаа эрх болно. Иргэн өөрийнхөө ялагдсан хэрэгт холбогдох хуулийн заалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд эргэлзээтэй байгаа

бол шүүхээр хэргийг нь хэлэлцэн амьдрал, хувь заяаг нь шийдвэрлэхээс өмнө эрх бүхий байгууллагад хандаж, шалгуулах нь зүйн хэрэг билээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад иргэний гомдлоор Цэцэд маргаан үүсгэхээр заасан нь “бусдаар дамжуулан өөр өөр мэдээлэл гаргах замаар ял зэмээс зайлсхийх боломж”-ийг хаах зорилготой. Учир нь онолын хувьд өргөдөл, гомдлыг иргэн өөрийнх нь хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхолтой холбоотой асуудлаар гаргадаг бол мэдээллийг бусад этгээдийн буюу нийтийн ашиг сонирхол, эрхийг хамгаалах зорилгоор гаргадаг. Нөгөө талаас ирүүлсэн өргөдөл, мэдээлэл бүрд Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэдэггүй, Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудал буюу Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааны шинжийг агуулж байгаа эсэхийг Цэцийн гишүүн хуульд заасны дагуу тогтоож, маргаан үүсгэх эсэхийг шийдвэрлэдэг.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх нь төрийн үүрэг юм. Энэхүү хууль зүйн баталгааг бүрдүүлэх нэг хэлбэр нь хэрэг түдгэлзүүлэх тухай асуудал бөгөөд хэргийг бүрэн илрүүлэх, хэргийг тал бүрээс нь бүрэн шалгаж, бодит байдлыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол,” гэж хуульчилсан болно.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.”, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасны дагуу шүүгч Үндсэн хуульд нийцсэн хуулийг хэрэглэж, Үндсэн хуульд нийцсэн үйл ажиллагааг явуулж, Үндсэн хуульд нийцсэн шийдвэрийг гаргах учиртай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хууль ёсны байх зарчмын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6, 33.4 дүгээр зүйлүүдээр Үндсэн хуулийн дээрх заалтуудыг бэхжүүлэн зохицуулсан. Дээрх хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын дагуу тухайн хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл үүсвэл хууль дээдлэх зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор хэргийг түдгэлзүүлэх эрхийг шүүгчид хуулиар олгосон. Өөрөөр хэлбэл, энэ нь шүүгч Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хуулийг хэрэглэж, хүний эрхийг зөрчсөн буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гаргахаас сэргийлэх зорилготой юм. Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцийн

дүгнэлт гаргасан эсэхээс үл хамаарч хууль хэрэглэдэг субъектүүд болох шүүгч, прокурор, түүнчлэн иргэн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий этгээдэд саналаа оруулсан л бол ажиллагааг түдгэлзүүлж байгаа нь хэргийн бодит байдлыг тогтоох, тал бүрээс нь хянан шинжилж шийдвэрлэх боломжийг хангахаас гадна шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ хууль дээдлэх, Үндсэн хуульд нийцсэн байх зарчмыг бэхжүүлсэн агуулгатай болно.

Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчөөгүй.” гэсэн байна.

Гурав. Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн Дунд суудлын хуралдаанаар хэлэлцэж 04 дүгээр дүгнэлтийг гаргасан байна. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Үндсэн хуулийн цэцэд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар маргаан үүсгэх нь тухайн хууль Монгол Улсын Үндсэн хуульд нийцэхгүй байгааг шууд илэрхийлэхгүй бөгөөд энэ үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх нь хүчин төгөлдөр хуулийн үйлчлэлийг үгүйсгэж, Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны хууль дээдлэх үндсэн зарчимд харшилж байна.

2.Гадаад улсуудын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжийг судалж үзэхэд, тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Үндсэн хуультай зөрчилдсөн гэж үзвэл шүүхээр дамжуулан Үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллагад хүсэлт гаргах зохицуулалт нийтлэг байх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.5 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг тогтоолгохоор Улсын дээд шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандсан бол” хэргийг түдгэлзүүлэхээр заасан нь олон улсын нийтлэг жишигт нийцэж байна.

3.Үндсэн хуулийн цэцэд тухайн эрүүгийн хэргийн оролцогч, эсхүл огт хамааралгүй этгээдийн өргөдөл, мэдээллээр маргаан үүсгэн хянан шийдвэрлэх тохиолдолд хэргийг түдгэлзүүлэхээр байгаа нь хэргийн бусад оролцогчдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндөж, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх боломжийг алдагдуулж, тэгш байдлыг хангах зарчмыг хөндсөн байна.

4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад "... гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол" гэсэн нь Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээлэл, эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлтийн дагуу хянан шийдвэрлэх Үндсэн хуулийн үзэл баримтлалд харшилж, хууль хоорондын зөрчилдөөнийг үүсгэсэн байгааг тэмдэглэх нь зүйтэй." гэсэн байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

"1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад "тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол," гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ." гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж заасныг зөрчсөн байна.

2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад "тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол," гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ." гэж заасныг тус тус Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. ..." гэсэн болно.

Дөрөв. Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг хэлэлцээд 2021 оны 5 дугаар сарын 20-ны өдөр "Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 04 дүгээр дүгнэлтийн тухай" 42 дугаар тогтоол гаргасан байна. Үүнд:

"1.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад "тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол," гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Шүүх хэрэглэх хууль

нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал ... -г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасныг зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Тав. Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“... 1.Монгол Улсын иргэн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад заасны дагуу Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхтэй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь иргэн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах Үндсэн хуульд заасан энэхүү эрхийг баталгаажуулсан зохицуулалтуудын нэг бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үр дагавартай онцлог харилцаа болохын хувьд зөвхөн уг ажиллагааны явцад буюу яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдаанд бэлтгэх шатанд онцгойлон яллагдагчид олгож байгаа эрх болно. Иргэн өөрийнхөө ялагдсан хэрэгт холбогдох хуулийн заалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд эргэлзээтэй байгаа бол шүүхээр хэргийг нь хэлэлцэн амьдрал, хувь заяаг нь шийдвэрлэхээс өмнө эрх бүхий байгууллагад хандаж, шалгуулах боломжийг олгож байгаа хэрэг билээ.

2.Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хүний эрх, эрх чөлөөг хангаууц хууль зүйн баталгааг бүрдүүлэх нь төрийн үүрэг юм. Энэхүү хууль зүйн баталгааг бүрдүүлж байгаа нэг хэлбэр нь хэрэг түдгэлзүүлэх тухай асуудал бөгөөд хэргийг бүрэн илрүүлэх, хэргийг тал бүрээс нь бүрэн шалгаж, бодит байдлыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол;” шүүгч хэргийг түдгэлзүүлнэ гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус хуульчилсан болно.

3. Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж, Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасны дагуу шүүгч Үндсэн хуульд нийцсэн хуулийг хэрэглэж, Үндсэн хуульд нийцсэн үйл ажиллагааг явуулж, Үндсэн хуульд нийцсэн шийдвэрийг гаргах учиртай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд хууль ёсны байх зарчмын хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6, 33.4, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг зэрэг зүйл, хэсгээр Үндсэн хуулийн дээрх заалтуудыг бэхжүүлэн тухайн хэрэглэх хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй нөхцөл үүсвэл хэргийг түдгэлзүүлэх эрхийг шүүгчид хуулиар олгосон. Өөрөөр хэлбэл, энэ нь хууль дээдлэх зарчмын хэрэгжилтийг хангах зорилгоор шүүгч Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хуулийг хэрэглэж хүний эрхийг зөрчсөн буюу Үндсэн хууль зөрчсөн шийдвэр гаргахаас сэргийлэх зорилготой юм.

Иймд хууль хэрэглэдэг субъект болох шүүгч тодорхой хуулийн заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Цэцийн дүгнэлт гаргасан эсэхээс үл хамаарч, нөгөө талаас иргэн асуудлыг шийдвэрлүүлэхээр эрх бүхий этгээдэд саналаа оруулсан л бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж байгаа нь хэргийн бодит байдлыг тогтоох, тал бүрээс нь хянан шинжилж шийдвэрлэх боломжийг хангахаас гадна шүүх, шүүгчийн үйл ажиллагаа, шийдвэр, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа бүхэлдээ хууль дээдлэх, Үндсэн хуульд нийцсэн байх зарчмыг хэрэгжүүлэх, иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан эрхийг баталгаажуулах агуулгатай болно.

Дээр дурдсаныг үндэслэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчөөгүй гэж үзэж, энэхүү тайлбарыг Танд хүргүүлж байна.” гэсэн байна.

ҮНДЭСЛЭЛ:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалт нь Үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээг хэрэглэн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, зөрчихөөс урьдчилан сэргийлэх, Үндсэн хуульд ёс болон хууль дээдлэх зарчмыг баталгаажуулахад чиглэсэн хэм хэмжээ байх бөгөөд хууль тогтоогч Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангауц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасны хүрээнд уг заалтыг бататган хуульчилсан байна.

Иргэдийн мэдээлэлд дурдсан шүүхийн практикт тэгш бус байдлаар тухайн заалтыг хэрэглэх явдал гарч байгаа гэх үндэслэл нь дээрх зохицуулалтын зорилго, агуулгатай шууд хамааралгүй, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахтай холбоотой асуудал болно.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтад “тухайн эрүүгийн хэрэгт хэрэглэх хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдлыг Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэн хянан шийдвэрлэж байгаа бол,” гэж, 34.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүх хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх маргаан Үндсэн хуулийн цэцэд үүссэн тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.” гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал ... -г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 04 дүгээр дүгнэлтийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Н.ЧИНБАТ
Д.ОДБАЯР
Ш.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Г.БАЯСГАЛАН
Ж.ЭРДЭНЭБУЛГАН
Д.ГАНГАБААТАР**



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 04

Улаанбаатар
хот

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 14.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Чинбат даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр, Ш.Солонго, Б.Буяндэлгэр, Г.Туулхүү, Г.Баясгалан, Ж.Эрдэнэбулган /илтгэгч/, Д.Гангабаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хаалттай хийв.

Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн П.Ундрах-Эрдэнэ, Л.Галбаатар, Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан нар оролцов.

Энэхүү хуралдаанаар Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан эцэслэн шийдвэрлэж, мөн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн “Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” 41 дүгээр тогтоолыг хянан хэлэлцэв.

Нэг. Монгол Улсын иргэн П.Ундрах-Эрдэнэ, Л.Галбаатар нар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж, Гүйцэтгэх ажлын тухай хуульд 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмсэн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн байна.

Учир нь хувь хүний амь бие, эрүүл мэнд, халдашгүй байдлыг хамгаалах үүрэг нь төрд байдаг бол хувь хүний нууцыг хамгаалах үүрэг зөвхөн хувь хүнд өөрт нь байдаг. Техник технологи хөгжсөн эрин үед хувь хүн өөрийн хууль ёсны эрх, эрх чөлөө, хувийн нууцаа техник технологийн шийдэлгүйгээр хамгаалах ямар ч боломжгүй юм. Жишээлбэл, иргэний гэр орон, албан өрөөнд хэн нэгэн этгээд хууль бусаар чагнах төхөөрөмж, нууц камер байрлуулсан байлаа гэж үзвэл түүнийг яаж илрүүлэх вэ? Үүнийг “нууц камер илрүүлэгч” гэх техник хэрэгслээр илрүүлэх боломжтой. Мөн хэн нэгэн этгээд хувийн болон албан өрөөнд нууцаар чагнах төхөөрөмж тавьсан бол мөн үүнийг “сүлжээ илрүүлэгч” гэх төхөөрөмжөөр илрүүлж болно.

Эдгээр төхөөрөмж буюу “нууц камер илрүүлэгч”, “сүлжээ илрүүлэгч” төхөөрөмжийг дэлхийн олон оронд илээр, чөлөөтэй худалдан борлуулдаг бөгөөд иргэд өөрсдийн аюулгүй байдлыг хангахын тулд зөвхөн өөрийн хэрэгцээнд ашиглахаар худалдан авч болдог байна. Үүнийг дэлхийн улс орнууд хуулиар хориглодоггүй. Учир нь өөрөө өөрийгөө хамгаалах эрх нь иргэний жам ёсны бөгөөд салшгүй эрх юм. Тухайлбал, гар утас хэрэглэгчийн хувьд тодорхой аппликейшнийг үнэгүй суулгаж хэрэглэх боломжтой бөгөөд онлайн худалдааны дэлгүүрүүдээс нууц камер илрүүлэгчийг худалдан авах боломжтой.

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг томьёолж хуульчлахдаа “илрүүлэх” зориулалттай техник хэрэгсэл, программ хангамжийг бүгдийг нь багтааж хэт өргөн хүрээнд томьёолсноос үүдэн иргэдийн хэрэглэдэг вирусийн программ хүртэл гүйцэтгэх ажлын хэрэгсэлд орох боломжтой мэт болжээ. Тухайлбал, энгийн вирусийн программ нь иргэдийн компьютерт халдаж буй хөнөөлт вирус, программыг таньж олох, “илрүүлэх” зориулалттай тул гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэсэн ангилалд хамрагдахаар ойлгомжгүй нөхцөл байдлыг үүсгэж байна. Улмаар өмнө хуулиар зөвшөөрдөг байсныг Эрүүгийн хуулиар шинээр гэмт хэрэгт тооцохоор оруулж, иргэний өөрөө өөрийгөө хамгаалах эрх, эрх чөлөөг хязгаарласан, дордуулсан байна.

Учир нь дээрх камер, сүлжээ илрүүлэгч төхөөрөмж нь “илрүүлэх” зориулалттай тул Гүйцэтгэх ажлын тухай хуульд зааснаар “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэх ангилалд багтаж, түүгээр зогсохгүй эдгээр төхөөрөмжийг олж авбал, ашиглавал гэмт хэрэг үйлдсэнд тооцон ял шийтгэгдэх үндэслэл бүрдсэн байна.

“Илрүүлэх” зориулалт бүхий техник хэрэгсэл нь нууцаар мэдээлэл цуглуулах, олж авах зориулалттай биш бөгөөд харин нууц техник хэрэгслийг таньж олох, илрүүлэх зориулалттай тул цэвэр хамгаалалтын хэрэгсэл гэж үздэг. Иргэд энэхүү илрүүлэх зориулалттай техник хэрэгслийг ашигласнаар өөрөө өөрийгөө хууль бус мөрдөн мөшгилт, тагнан чагнах

үйл ажиллагаанаас сэргийлэх, өөрийн мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах ач холбогдолтой юм. Гэтэл нууцаа хамгаалах хамгаалалтын арга хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглах эрхийг дээрх зохицуулалтаар үгүйсгэсэн нь хүний эрхийн ноцтой зөрчил гэж үзэхээр байна.

Иймд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн дээрх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэснийг тус тус зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“1.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт төр улсынхаа тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх нөхцөлийг хангах үүргийг хүлээж, энэ зорилгоор хуульд заасан тодорхой нөхцөл журмын хүрээнд холбогдох байгууллага тусгай чиг үүргийг хэрэгжүүлж болохоор тогтоосон байна.

2.Хууль тогтоогч “гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийг” ашиглах байгууллага, албан тушаалтныг Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт зэрэг хууль тогтоомжид нэрлэн зааж, хуулиар эрх олгоогүй этгээд ашиглах, борлуулахыг хориглосон нь иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, мөн хуульд заасан үндэслэлээр зөвшөөрөгдсөн мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлж буй бодлогын хүрээнд уг хуулийн заалтыг баталсан.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 12 дугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйл, Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 3.4, 3.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу аливаа илрүүлэх төхөөрөмж буюу нууц камер, нууц камер болон долгион илрүүлэгч, яриа болон GPS байрлал дамжуулах төхөөрөмж, үзгэн камер, флашан камер, адаптер камер буюу энгийн хэрэглээний эд зүйлд суурилуулсан нууц камер зэрэг төхөөрөмжүүдийг

иргэн, хуулийн этгээд өөрийн өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, өөрийн болон гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглах эрхийг хуулиар ялгаатай зааглан тогтоожээ.

Иймд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна. ...” гэжээ.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэж, 03 дугаар дүгнэлтийг гаргасан болно. Уг дүгнэлтийн үндэслэл хэсэгт:

“1.Монгол Улсын Их Хурал Гүйцэтгэх ажлын тухай хуулийг 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталж, тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт ““Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж тодорхойлсон нэмэлтийг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар оруулжээ. Улмаар гүйцэтгэх ажлын тусгай техникийг хуулиар эрх олгогдоогүй этгээд олж авсан, ашигласан, борлуулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн 21.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт оруулан хуульчилсан байна.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад Монгол Улсын иргэн “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;” гэж зааж хүний хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг үндсэн эрх хэмээн баталгаажуулсан байна.

Уг заалт нь халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмаар хязгаарлах төдийгүй дур мэдэн халдахыг хориглосон зохицуулалт юм. Ийнхүү “дур мэдэн” гэж заасан нь хуулиас гадуур хүний эрхийг хязгаарлахыг хориглосноос гадна хэт ерөнхий, өргөн хүрээнд, хоёрдмол утгаар тайлбарлаж болохуйц хэм хэмжээг тогтоохыг хориглосон агуулгыг илэрхийлнэ. Энэ нь эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтан ийм хуулийг дур зоргоор тайлбарлан хэрэгжүүлж, хүний эрх, эрх чөлөөг зөрчих эрсдэлтэй байдагтай холбоотой юм. Иймд Монгол

Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

3.Хууль тогтоогч хүний хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хязгаарлах үндэслэл журмыг тодорхойлохдоо тухайн хуулийг хэрэгжүүлэх байгууллага, иргэдэд хоёрдмол утгагүй, тодорхой ойлгогдохоор томъёолох, иргэд уг хуулийг зөрчсөнөөс үүсэх үр дагавар, хүлээх хариуцлагын талаар урьдчилан таамаглах, мэдэх боломжтой байхаар хуульчлах үүрэгтэй. Ингэснээр хууль хэрэгжүүлэгч байгууллага болон шүүх хуулийг нэг утгаар хэрэглэх, эрх, эрх чөлөө нь тухайн хууль тогтоомжоор хязгаарлагдаж буй иргэн зан үйлээ хуульд нийцүүлэх, эрх зүйн үр дагаврыг урьдчилан харж, таамаглах нөхцөл бүрдэнэ. Энэ нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн зохицуулалтын нөхцөл, зорилго, хүрээг зохицуулж буй харилцааны онцлогт нийцүүлэн тодорхой, ойлгомжтой томъёолон хуульчлах буюу хууль зүйн тодорхой байдлыг хангах зарчимтай холбоотой юм.

4.Мэдээлэл гаргагч иргэд болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, түүнчлэн Тагнуулын ерөнхий газар, Монгол Улсын ерөнхий прокурорын газраас гаргуулж авсан тайлбар, баримтаас үзэхэд тус маргаан бүхий зохицуулалтын агуулгыг харилцан ялгаатай байдлаар ойлгож, тайлбарлаж байгаа нь харагдаж байна. Мөн шинжээчийн дүгнэлтэд “... Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийг ... хүн уншаад өөрийн зан үйлээ зохицуулах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, ... хүн ямар техник хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд Тагнуулын ерөнхий газраас тухайн техник хэрэгслийг хураан авах, эсхүл авахгүй байхыг урьдчилан тооцох боломжгүй байна. ...” гэжээ.

Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл гэх ойлголтод хамаарах “илрүүлэх” төхөөрөмж гэдэгт нууц камер илрүүлэгч гар утасны программ, цахим халдлагаас сэргийлэхээр бүтээгдсэн компьютерын программ хангамж зэрэг хамаарах эсэх нь тодорхойгүй буюу иргэн өөрийн хувийн мэдээллийг хамгаалах зорилгоор ямар төхөөрөмж, программ хангамжийг ашиглах боломжтой эсэх нь ойлгомжгүй байна. Дээрхээс үзвэл Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн маргаан бүхий зохицуулалт нь хууль тогтоомж тодорхой байх Монгол Улсын Үндсэн хуулийн шаардлагад нийцэхгүй байх ба иргэд хууль, тогтоомж зөрчсөнөөс үүдэх эрүүгийн хариуцлагын талаар урьдчилан таамаглах, зан үйлээ хуульд нийцүүлэн өөрчлөх боломжийг хязгаарлаж, хувь хүн өөрийн нууцаа хамгаалах, халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

5.Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн эсэхийг тогтооход хэрэглэдэг түгээмэл шалгуур нь тэнцвэрийн зарчим юм. Энэ зарчмын хүрээнд төрийн хууль ёсны зорилгод нийцүүлэн иргэний

эрх, эрх чөлөөг хуулиар хязгаарлах боломжтой. Холбогдох зохицуулалтыг Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлтээр оруулахдаа хууль тогтоогч уг заалтын зорилгын талаар тухайлан хэлэлцээгүй байна. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс ирүүлсэн тайлбарт иргэний хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх, мөн хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлж буй бодлогын хүрээнд уг хуулийн заалтыг баталсан талаар тэмдэглэжээ.

6. Эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох чиглэлээр нууц ажиллагаа хийх зэрэг ажилд саад учруулахаас сэргийлэх хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7 дахь заалтад тусгасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх Засгийн газрын бүрэн эрхэд хамаарах төрийн хууль ёсны зорилго мөн байна. Харин энэ зорилгын хүрээнд хувь хүний нууц болон мэдээллийг цуглуулах, дамжуулах, нууцаар олж авахад чиглэсэн хөндлөнгийн халдлагаас хамгаалах иргэний эрхийг хуулиар хязгаарласан нь хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг зөрчсөн байх үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хамгаалалтад иргэн өөрийн гэр бүл, захидал харилцаа, орон байрны халдашгүй байдлаа хууль бус халдлагаас хамгаалах болон хуулиар хамгаалуулах эрхтэй. Энэ нь хувь хүн, бусад этгээдээс гадна төрийн байгууллага, албан тушаалтны халдлагаас сэргийлэхтэй холбоотой зохицуулалт юм. Иргэний хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан нь хүний эрхэм чанарыг дээдлэхтэй холбоотой бөгөөд иргэн бусдын хууль бус халдлагаас ангид байдлаар бие даан орших, өөрийн мөн чанар, үзэл бодол, итгэл үнэмшил, мэдрэмжээ илэрхийлэх хувийн орон зайг нь хамгаалахад чиглэнэ.

7. Эрүүгийн хэргийг илрүүлэх болон нийтийн ашиг сонирхолд аюул учруулахуйц тохиолдолд энэхүү эрхийг хуулиар хязгаарлах боломжтой боловч хувь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн хязгаарлалт нь тэнцвэрийн зарчимд нийцсэн байх шаардлагатай. Уг маргааны хувьд иргэн өөрийн хувийн амьдрал, мэдээллийн нууцыг өөрөө хамгаалах, хөндлөнгийн халдлагаас сэргийлэх боломжийг хориглох замаар эрүүгийн хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоох нь хуулийн холбогдох зохицуулалтын зорилго гэж үзэхээр байна.

Хүний хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхийг ийнхүү хязгаарлахгүйгээр уг хуулийн зорилгод хүрэх боломжтой байна. Тухайлбал, илрүүлэх тоног, төхөөрөмжийг ашиглах зорилгоос хамааран хэрэглээнд нь

хуулиар хязгаарлалт тогтоож болно. Үүнээс үзэхэд хуулийн зохицуулалтын зорилго болон тухайн зорилгод хүрэхэд чиглэсэн арга хэмжээ нь зохист нийцэлгүй байна. Гэмт этгээдийг олж тогтоох гүйцэтгэх ажиллагаанд саад тотгор учруулахгүйгээр өөрийн хувийн мэдээлэл, орон байр, захидал харилцааны халдашгүй байдлыг хамгаалах зорилгоор илрүүлэх төхөөрөмжийг ашиглахыг иргэнд зөвшөөрөх замаар дээр дурдсан хуулийн зорилгод хүрэх боломжтой байна. Ийнхүү иргэний өөрийн болон гэр бүлийн халдашгүй байдал, хувийн нууцаа хамгаалах эрхийг хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн нь уг хуулийн зохицуулалтын зорилго биелснээр олж болох давуу талтай харьцуулахад илүү эрсдэл бүхий үр дагавартай байна.

Иймд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн маргаан бүхий зохицуулалт нь хууль зүйн тодорхой байдлын зарчим болон тэнцвэрийн зарчмын дагуу тавигдах шалгуурт нийцээгүй, улмаар иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд дур мэдэн халдах, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүрэг зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.” гэсэн байна.

Дүгнэлтийн тогтоох хэсэгт:

“1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “... илрүүлэх ...” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй. ...” гэсэн байна.

Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дээрх дүгнэлтийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд 41 дүгээр тогтоол гаргажээ. Үүнд:

“1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэж заасны “... илрүүлэх ...” гэсэн нь Монгол

Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.” гэсэн байна.

Тав. Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбартаа:

“... Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор гүйцэтгэх ажлын тусгай техник, хэрэгслийг зөвхөн эрх бүхий байгууллагууд үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор ашиглах зохицуулалттай.

Маргаан бүхий асуудлаар Үндсэн хуулийн цэцэд гаргасан нэр бүхий иргэдийн мэдээлэл, гомдлын агуулгаас үзэхэд, зөвхөн “хууль бусаар” тагнаж, чагнасан тохиолдолд тусгай техник, хэрэгслийг хэрхэн илрүүлж, хувийн халдашгүй, чөлөөтэй байх эрхээ хамгаалах талаар тусгасан байна. Үүнтэй холбогдуулан “хууль бус”-аар халдах гэдэгт гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан, эсхүл гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан гэсэн хоёр ойлголт гарч ирнэ. Дээрх хоёр тохиолдолд аль аль нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг болох бөгөөд эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсны үндсэн дээр шүүхээр гэмт хэрэг үйлдсэн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэнэ.

Харин иргэний хувьд, аливаа этгээдийн хууль бус халдлагаас хамгаалах, түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах зориулалттай тоног төхөөрөмж суурилуулсан эсэхийг “илрүүлэх” зорилгоор тусгай зориулалтын техник, хэрэгслийг ашиглах нь дээр дурдсан хоёр тохиолдлоос бусад буюу эрх бүхий байгууллагаас хуульд заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд саад учруулна. Учир нь иргэн өөрт чиглэсэн ажиллагаа хууль бусаар явагдаж байгаа, эсхүл эрх бүхий байгууллагаас хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа гэдгийг ялгах, мэдэх боломжгүй юм. Улмаар үндэсний аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр явуулж буй эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нууц, далд аргаар явагддаг тул түүнийг тухайн ажиллагаа чиглэсэн болон бусад этгээдэд аливаа хэлбэрээр задруулахыг хориглож, хэрэв задруулсан тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан. ...

Аливаа этгээдээс Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан “илрүүлэх” зориулалттай техник, хэрэгслийг олж авсан ашигласан, борлуулсан үндэслэлээр Эрүүгийн хуулийн 21.13

дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд тухайн техник, хэрэгсэл нь “илрүүлэх” зориулалттай техникт хамаарах эсэхийг тусгай мэдлэг бүхий шинжээчээр тогтоолгохоос гадна гэмт хэрэгт шалгагдаж байгаа этгээдийн хувьд тусгай зориулалт бүхий гэдгийг мэдсэн, эсхүл мэдэх боломжтой байсан зэрэг сэдэлт, зорилгыг зайлшгүй шалгаж тогтоосны эцэст хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэнэ.

Прокурорын байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Прокурорын тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар дээрх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргээ тасралтгүй, нэг мөр хэрэгжүүлэн ажиллаж, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу зайлшгүй тохиолдолд мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах зөвшөөрлийг олгож, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна.

Дээрх тайлбар, үндэслэлтэй холбогдуулан, хүн ямар техник, хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд хуульд заасан хариуцлага хүлээх, түүнийг тагнуулын байгууллагаас хураан авахыг урьдчилан тооцох боломжтой байх шаардлагын хувьд тусгай зориулалтын техник, хэрэгсэл гэдэгт ямар нэр, төрлийн төхөөрөмж орох талаар хуульд нэг бүрчлэн заах боломжгүй. Харин Гүйцэтгэх ажлын тухай хуулийн “нэр томьёо” хэсэгт “илрүүлэх” тоног төхөөрөмжийн зориулалт, онцлогийг дэлгэрэнгүй, ойлгомжтой байдлаар тусгах байдлаар шийдвэрлэх нь зүйтэй.

Иймд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “илрүүлэх” гэдгийг хассан тохиолдолд гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хүндрэл үүсэх, улмаар үндэсний аюулгүй байдлын эсрэг гадаад улсын тусгай алба, байгууллага, иргэн, тэдгээртэй хамтран ажиллаж байгаа этгээдээс явуулж байгаа ажиллагааг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах ажиллагаанд нууцлал, аюулгүй байдал алдагдах эрсдэл үүснэ гэж үзэж байна.” гэжээ.

Зургаа. Уг маргааныг эцэслэн шийдвэрлэх Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдаанд бэлтгэх ажлын хүрээнд Монгол Улсын Их Хурал, Тагнуулын ерөнхий газар, Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас тайлбар, тодруулга, баримт гаргуулан авсан бөгөөд ирүүлсэн тайлбар, баримт нь төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэл агуулсан байна.

ҮНДЭСЛЭЛ:

Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгсэл” гэж мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар олох, цуглуулах, дамжуулах, хүлээн авах, илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ

хангамжийг хэлнэ.” гэж заасны “... мэдээ, өгөгдөл, баримт сэлтийг нууцаар ... илрүүлэхэд зориулагдсан техник, тоног төхөөрөмж, түүний бүрдэл хэсэг, программ хангамжийг хэлнэ.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтад “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. ... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Хүний эрхийг баталгаажуулах хүрээнд Гүйцэтгэх ажлын тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгон нэр томъёог хоёрдмол утгагүйгээр хуульчлах нь зүйтэй байгааг тэмдэглэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2, 32 дугаар зүйлийн 2, 36 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ТОГТООХ НЬ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн “Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 03 дугаар дүгнэлтийг хүчингүй болгосугай.

2. Энэхүү тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ
ГИШҮҮД**

**Н.ЧИНБАТ
Д.ОДБАЯР
Ш.СОЛОНГО
Б.БУЯНДЭЛГЭР
Г.ТУУЛХҮҮ
Г.БАЯСГАЛАН
Ж.ЭРДЭНЭБУЛГАН
Д.ГАНГАБААТАР**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeleel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2

Индекс: 200003